

**“НИЙСЛЭЛИЙН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ХЭМЖЭЭНД 2018 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ
АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ”-НИЙ 2018 ОНЫ 2 ДУГААР УЛИРЛЫН БИЕЛЭЛТ**

2018.07.10

Улаанбаатар хот


Д/д	Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа	Төлөвлөгөөний биелэлт	Хэрэгжилтийн хувь
1	Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлан ажиглах, энэ талаарх мэдээллийг иргэд байгууллага, чөлөөтэй авах нөхцөлийг хангах	Авлигын эсрэг хууль тогтоомж, зохион байгуулж буй арга хэмжээг цахим болон бусад хэлбэрээр сурталчлах	Жилдээ	Авлигын эсрэг хууль тогтоомж, зохион байгуулж буй арга хэмжээний тухай мэдээ мэдээллийг сурталчлан, байгууллагын цахим сайт болон мэдээллийн самбарт тогтмол байршуулан ажиллаж байна.	100%
2	Хүний нөөцийн ил тод байдлыг хангах, олон нийтийг түүнтэй танилцах боломжоор хангах	Сул орон тооны зар, сонгон шалгаруулалтын талаарх мэдээлэл, албан хаагчийн ажиллах журам, харилцах утас зэргийг цахим хуудас болон мэдээллийн самбарт мэдээлэх	Тухай бүр	Нээлттэй ажлын байрны зарыг байгууллагын www.khangardi.mn цахим сайт болон мэдээллийн самбарт тогтмол байршуулан нийтэд мэдээлэхийн зэрэгцээ дүүргүүдийн хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэст ажлын байрны сул орон тооны захиалгыг өгч байна. Мөн хүний нөөц бүрдүүлэлтийн талаарх мэдээллийг цахим сайт болон мэдээллийн самбарт байршуулан, ил тод байдлыг ханган ажиллаж байна.	100%
3	Хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах, мэдээлэх, хяналт тавих ажлыг хуулийн дагуу зохион байгуулах	Мэдүүлэг гаргагч албан тушаалтны хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг, мэдэгдэл, тайлбарыг бүртгэх, хянах, хадгалах ажлыг журмын дагуу зохион байгуулах, урьдчилсан мэдүүлгийг хянуулаагүй албан тушаалд томилсон тохиолдолд хариуцлага тооцож, нийтэд мэдээлж ажиллах	Жилдээ	Шинээр удирдах албан тушаал болон хөрөнгө итгэмжлэн хариуцах албан тушаалд томилогдсон нийт 4 ажилтны ХАСУМ-ын мэдүүлгийг гаргаж, АТГ-т хүргүүлсэн. Үүнээс нийт 3 албан хаагч нь тухайн албан тушаалд томилогдон ажиллах боломжтой талаар хариу хүлээн авсан ба 1 албан хаагчийн хариу ирэх хугацаа болоогүй байна. Мөн тайлант хугацаанд урьдчилсан мэдүүлгийг хянуулалгүй албан тушаалд томилсон зөрчил гараагүй болно.	100%

4	Эрх бүхий албан тушаалтнууд, мэдүүлэг гаргагч нарт мэдүүлгийн бүрдүүлэлтийн талаар сургалт зохион байгуулах, гарын авлага материал тараах	Жилдээ	Тайлант хугацаанд уг чиглэлээр сургалт зохион байгуулагдаагүй болно.	100%
5	Төрийн албан хаагчдад шударга ёс, ёс зүй сонирхлын зөрчлийн талаар сургалт зохион байгуулах, шударга байдал, түүнийг нэмэгдүүлэх арга хэмжээг авч ажиллах	Жилдээ	Нийт ажилтан, албан хаагчдын мэдээллийн цагаар НЗДТГ-ын Хууль эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн Б.Ууганжаргал "Төрийн албан хаагчийн ёс зүй" сэдвээр нийт ажилтан, албан хаагчдад сургалт, мэдээлэл өгсөн. Дээрх сургалтад байгууллагын Захиргаа, санхүүгийн хэлтэс, Байр ашиглалтын алба, Үйлчилгээний албаны 250 гаруй ажилтан, албан хаагч хамрагдсан болно. Мөн Улсын мөрдөн байцаах газрын мөрдөх албаны дүн шинжилгээ хяналт хариуцсан ахлах мөрдөн байцаагч дэд хурандаа Э.Нэмэхжаргал "Хариуцлага, сахилга бат, ёс зүй" сэдвээр мэдээлэл хийсэн. Тус мэдээлэлээр шинээр мөрдөгдөж буй хууль дүрэм, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай, хувь хүний хариуцлага, сахилга бат, ёс зүйн талаар зөвлөгөө мэдээлэл өглөө.	100%
6	Авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдол ирсэн тохиолдолд шуурхай шийдвэрлэж ажиллах	Жилдээ	Тайлант хугацаанд авилга, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдол ирээгүй ба энэ нь газрын хэмжээнд авлигын эсрэг хууль тогтоомжийг чанд мөрдөн ажиллаж буйн илрэл юм.	100%
7	Албан хаагчийг хууль бусаар ажлаас халах, тушаал бууруулах, нэр төр, алдар хүндийг гутаах зорилгоор санаатайгаар гүтгэсэн нь тогтоогдвол нэр төрийг нь	Жилдээ	Тайлант хугацаанд хууль бусаар ажлаас чөлөөлөгдсөн, албан тушаал бууруулсан, хууль ёсны нэр хүндэд нь халдсан талаар гомдол маргаан гараагүй болно.	100%

		сэргээх, хамт олон, олон нийтэд мэдээлдэг болох			
8	Авлигын эсрэг нийслэлээс явуулж буй бодлого, шийдвэрийг иргэдэд сурталчлах, энэ талаарх мэдээ мэдээллийг иргэн, байгууллага чөлөөтэй авах нөхцөлийг бүрдүүлэх	Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах, шударга, ёс зүйтэй төрийн албыг төлөвшүүлэх талаар үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бусад байгууллагуудтай хамтран ажиллах	Жилдээ	АТГ, НЗДТГ-тай хамтран зохион байгуулсан нийтийн албан тушаалтанд зориулсан ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай болон худалдан авах үйл ажиллагаатай холбоотой сургалтад НҮГ-ын Захиргаа, санхүүгийн хэлтсийн 18 албан хаагч хамрагдсан. Цаашид энэ чиглэлээр зохион байгуулагдах сургалтад бусад 27 албан хаагч хамрагдахаар мэдээллийг хүргүүлсэн.	100%
9	АТГ-аас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх, тайлагнах	АТГ-аас ирүүлсэн зөвлөмж, шийдвэрийг тухай бүр биелүүлж ажиллах	Жилдээ	Авилгатай тэмцэх газраас ирсэн зөвлөмж шийдвэрийг дагаж мөрдөн, авилгын эсрэг хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажиллаж, мэдээ тайланг улирал бүр эрх бүхий байгууллагад хүргүүлэн ажиллаж байна.	100%


ХЯНАЖ, ТАНИЛЦСАН

ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

 Ч.ШИНЭЧИМЭГ

ТАЙЛАН ГАРГАСАН:

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН
ХЭРЭГЖИЛТ ХАРИУЦСАН АЖИЛТАН

 Э.ХОРОЛДУЛАМ